

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/41

Арвайхээр сум

Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг
шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 31.4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн “Өмч хамгаалах зөвлөлийн журам батлах тухай” 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Зөвлөлийн ахлагч: Ахлах нягтлан бодогч

Гишүүд: Ахлах мэргэжилтэн (Хууль эрх зүй, дотоод хяналт хариуцсан)

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан ажилтан

Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал, ёс зүй, хариуцсан мэргэжилтэн

Халдварт өвчин, дархлаажуулалтын мэдээ, мэдээлэл, хүйтэн хэлхээ хариуцсан ажилтан

2. Олон улсын байгууллагын хандив тусламж, улс, орон нутгийн төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр олгогдож буй тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, барилга, үндсэн хөрөнгийн бүртгэл, худалдан авалт, хадгалалт, хөрөнгө актлах, устгах, зарцуулалтад дотоодын хяналтын тогтолцоог бүрдүүлэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг ахлах нягтлан бодогч (Б.Валя)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, Үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал) нарт тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2011 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн “Байгууллагын өмч хамгаалах зөвлөл байгуулах тухай” 41 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.ОЮУНТУЯА

622501155
D:My.Doc.Tushaal, EMG